

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

|   |                        |                     |             |
|---|------------------------|---------------------|-------------|
| Ярилцлага өгөгчийн нэр                              | Банзрагчийн Даваасүрэн | Дугаар              | L100        |
| Оршин суугаа аймаг                                  | Хэнтий                 | Оршин суугаа сум    | Жаргалтхаан |
| Төрсөн газар  | Жаргалтхаан сум        | Төрсөн он           |             |
| Ажил мэргэжил                                       | Малчин                 |                     |             |
| Лам байсан эсэх,<br>Шавилан сууж байсан сүм<br>хийд | Мэргэн хамбын хүрээ    | Сүм хийдийн дугаар  | ХЭЖХ 015    |
| Одоогийн сүм хийд                                   |                        | Сүм хийдийн дугаар  |             |
| Ярилцлага авсан он сар<br>өдөр                      | 2007 оны 6-р сарын 14  | Ярилцлага авсан хүн | Ж.Одгарьд   |



Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Мэргэн хамбын хүрээ

-Та энэ нутгийн хуучин хийдүүдийн талаар өөрийн мэдэж байгаа зүйлүүдээс болон Мэргэн хамбын хурлын тухай мэдэж байгаа зүйлээ ярьж өгнө үү?

93 настай Пүрэвдаш гэдэг хүний ярьж байсныг би сонссон юм. Тэгээд тэр Ганжуур туслагчийн улаан жинс гэж байгаа юм тэр ямар ч байж болно, хөх жинс хоёрыг өөр жаахан хатуу эдтэй хамт хайрцаганд хийгээд хүнд үзүүлж болохгүй гээд өгсөн гэдэг.

-Тайжийн Дамдин гэлэн гэдэг хүнд өгсөн юм үү?

- Үгүй өөр хүнд яг баригдахынхаа өмнө өгсөн гэсэн. Миний ээлж боллоо, ингэж яваад эргэж ирэхгүй нь мэдээж. Тэгэхээр энэ хоёр зүйлийг хадгалж бай гэсэн гэдэг. Тэгээд өвгөн нуусан л юм байна л даа.

- Ямар дуганаас гэдэг байсан вэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

- Тэгээд Голбогийн дуганаас л алхмаар хэмжиж газар булсан гэдэг. Цаг өөрчлөгдсөний дараа өнөөх өвгөн нөгөөдөхөө үзсэн юм байна лээ. Тэгсэн чинь олоогүй гэж байгаа юм.

-Уугийн хурлын тухай? Тэнд яг сууж байсан хүмүүсийн талаар? Дэндэв гуай яг тэнд сууж байсан уу?

- Дэндэв гуайг бага унзад байсан гэж дуулсан юм байна. Би худлаа ч ярьж байж магадгүй. Би хүмүүсийн яриаг сонссон юм. Яг мэдэх хүмүүс байхгүй. Сонссон хүмүүс л байгаа.

-Уугийн хурал хэр олон дугантай байсан юм болоо?

- Уугийн хурлыг сайн мэдэхгүй. Мэдэх хүн байхгүй. Мөнгөн бүрээ гэж сонссон. Харин тэр зүүн урд нь нэг овгор байсан. Тэр харин хөндий юм шиг байсан. Самбуу өвгөнтэй урагшаа Хараа гол дээр морьт услах гээд байж байхдаа хөндий гэдгийг нь мэдсэн. Урьд нь дуулж ч байсан. Одоо тэр өвгөн нас барсан. Тэгсэн Балдандугар гуай болохоор тэр хөндийг олчихсон дээр нь цохисон чинь дуугарч байсан гэж ярьсан. Тэгсэн Самбуу гуай уурлаад юу гэж хөндий газар пөн пөн гэж дуугардаг юм гэсэн. 70 гарч байгаа өвгөн худлаа ярих гэж өвгөн Самбуу гуайд уурлаад байдаг юм гэж хэлж байсан. Баатарын дацангийн зүүн урд талд байдаг юм. Би тэрийг мэдэж байгаа. Зүүн толгойд нь хог нь ч байсан юмуу, би ер нь тэрүүгээр хонь хариулаад явж байхдаа энд нэг дуган байсан, худаг нь энд байсан гэж байгаа юм гээд сонирхоод л өөрөө өөртэйгээ ярьж явдаг юм. Тэгэхээр тэнд хог байсан юмуу эсвэл бурхан энэ тэр шатаасан юмуу зүгээр нэг газраас арай бөмбөгөрдүү гүвгэр байдаг юм. Зүгээр өвгөн бид хоёр өдөр морьтой тэрүүгээр явж байхад тэгж санагдсан. Тийм юм болов уу гэх юм өвгөн ярьсан.

-Та өөрөө Баатарын дацангийн тэр хавиар нутагладаг уу?

Тиймээ.

-Хамбын отгийн талаар таны өвгөчүүдээс дуулсан юм байна уу?

Яг Хамбын отгийн хүн чинь Рэнцэндорж, Хайв, Цамба гурав л байгаа юм шүү дээ.

-Хамбын отгийн лам нараас тэнд хурал хүрж байсан гэсэн хууччуулын сураг байсан уу?

Байгаагүй байхаа.Цамба чинь харин яг энэ нутгийн уугуул хүн байгаа юм. Энэ талаар мэдэх хүн байгаа юм. Хамбын отгын уугуул хүн байгаа юм. Цамба гуай аймгийн аврага, намын гишүүн коммунист хүн байсан. Бүх юмнуудаа аваачиж өгөөд ардчилсан намд элсчихсэн хүн байгаа юм. Зарим хүн дургүйцдэг юм. Хувсгалт намаа солиод дураараа их юм хийсэн хүн. Нэлээн нэр хүндтэй хүн байгаа юм. Хүний ярьсаныг дууссан дуустал нь л сонсдог хүн. Тэр хүнтэй очиж уулзахад гэмгүй дээ.